



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/100

Шивээговь сум

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2 дугаар багийн малчин М.Билэгдэмбэрэл, Ц.Баярсайхан нарын суурьт бүртгэгдсэн гоц халдварт бог малын мялзан өвчний хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс малын өвчлөл илрээгүй тул аймгийн Мал эмнэлгийн газраас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/111 тоот саналыг үндэслэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2.Хязгаарлалтын дэглэмийг цуцалсан ч 2 дугаар багийн малчин М.Билэгдэмбэрэл, Ц.Баярсайхан нарын малын шилжилт хөдөлгөөнд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (А.Цэрэндолгор), 2 дугаар багийн Засаг дарга (Д.Маналмаа) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэдэд бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (П.Ганжаргал), сумын Засаг даргын орлогч (Ч.Сугармаа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ